



## **Оюу Толгой ХХК**

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа болон Байгаль орчны Удирдлагын тогтолцооны журам

14-р хэсэг. Үл-тохирол, осол зөрчил, авах хариу арга хэмжээ

Осол зөрчлийн удирдлагын журам:

- Мэдэгдэх, бүртгэх, мэдэлэх
- Судалгаа
- Баримтжуулалт
- Хяналт, баталгаажуулалт

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

## 1. ЗОРИЛГО

Уг журмын зорилго нь гарсан бүх үл-тохирлын тохиолдол болон осол, зөрчлийг мэдэгдэж, түүнийг судлаж, цаашид дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор засч залруулах, урьдчилан сэргийлэхийн тулд авах арга хэмжээг тодорхойлох, түүнээс авсан сургамжийг бусдад мэдээлэхэд оршино.

Осол зөрчилд дараах зүйлс тохиолдсон, эсвэл тохиолдох боломжтой (осолд дөхсөн тохиолдол) үйл явдлууд хамаарна;

- Ажлын байран дахь гэмтэл бэртэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөл
- Биет хөрөнгө (үйлдвэр, тоног төхөөрөмж гэх мэт), байгаль орчин (зэрлэг амьтан, шувууд, мал сүрэг), үйл явц/ажиллагаа, бүтээгдэхүүн буюу нэр хүндэд учрах хохирол
- Орон нутгийн иргэдэд хүндрэл учруулах. Үүнд Оюу Толгой төслөөс орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, амьжиргаа, мал сүрэгт шууд эсвэл шууд бусаар үзүүлсэн сөрөг нөлөөлөл, түүнчлэн соёлын өвийг хөндөх, гэмтээх, орон нутгийн иргэдийн ашиглаж буй газрыг зөвшөөрөлгүй хөндөх, сүйтгэх зэрэг тохиолдлууд багтана.
- Хууль эрхзүйн шаардлага биелүүлээгүйгээс хариуцлага хүлээхээр татагдах
- Аюулгүй байдалд аюул занал учрах
- Хууль эрхзүйн хэрэгжилт болон бизнесийн ёс зүй
- Үйл ажиллагааны зөвшөөрсөн түвшинг хэтэрч, ажлын байрны өртөлтийн хязгаарыг (АБӨХ) зөрчсөн
- Гадаад оролцогч талууд, үйлчлүүлэгчдээс ирсэн санал гомдол (орон нутгийн иргэд үүнд багтана)
- Бусад үүрэг амлалтын зөрчил (Байгаль орчны зөвшөөрлийн нөхцөл, үүрэг амлалт, Үйл Ажиллагааны Удирдлагын Төлөвлөгөө (баримтжуулсан БОННУ–ний үүрэг амлалт) болон бусад ЭМААБО-ны үүрэг хариуцлага, стандарт, шаардлагын үл тохирол)

Бүх үйл явдлыг Осол зөрчлийн удирдлагын журмын дагуу зохицуулна.

МУ–ын хууль тогтоомжид заасан шаардлагуудыг хангах үүднээс ажлын бус цагийн амралт болон гэр ажлын хооронд зорчих үед гарсан осол, зөрчлийг судлан шинжлэх, арга хэмжээ авах зорилгоор түүнийг мэдээлэх (Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх тухай дүрмийг шинэчлэн батлах тухай МУ-ын ЗГ-ын 14-р Тогтоол) боловч Ажлаас гадуурх осол, зөрчил (ажлаас гадуурх гэмтэл/өвчлөл) хэмээн ангилна.

Аудит, хяналт шалгалтаар илэрсэн үл тохирол, эрхзүйн шаардлагын зөрчлийг 16–р Хэсэг Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, аудитын журам (ОТ-16-PRC-0001-М)-д заасан шаардлагын дагуу зохицуулна.

## 2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ журмыг Оюу Толгой (ОТ) ХХК-н бүх үйл ажиллагаа болон төслийн талбай дахь үндсэн ба гэрээт ажилтнууд, зочид мөрдөнө.

Энэ журамд ОТ ХХК –н наад захын шаардлагуудыг тодорхойлсон болно. Ашиглалтын үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэх үүднээс удирдах ажилтнууд энэхүү журмыг нэмэн дэлгэрүүлж болно (тайлагнах хугацааг богиносгох буюу нэмэлт тайлан, мэдэгдэл гаргах зэрэг). Энэхүү журмыг дараах холбогдох журам, ажлын явцын тойм зургийн хамт хэрэгжүүлнэ:

- Осол зөрчлийн удирдлага: Гэмтэл/өвчлөлийг ангилах, мэдээлэх журам

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

- ЭМААБО–ны тогтмол мэдээлэх, тайлагнах журам
- Хариу арга хэмжээний удирдлагын журам

Рио Тинтогийн Бизнес Шийдэл (РТБШ)–ийг бүх осол, зөрчил, холбогдох гэмтэл/өвчлөл, авсан арга хэмжээг бүртгэхэд ашиглана.

### **3. АЛБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА**

Осол зөрчлийн удирдлагын журам: Албан тушаал, үүрэг хариуцлага (ОТ-14-PRC-0002-М)–баримт бичгээс лавлана уу.

Бусад осол, зөрчил, арга хэмжээний удирдлагыг зохих мэргэжлийн салбар нэгжийн дэмжлэгтэйгээр холбогдох үйл ажиллагааны нэгж хариуцан явуулна. Осол зөрчлийг хариуцах удирдах ажилтан, үйл ажиллагааны салбар нэгжийг тодорхойлохдоо осол зөрчлийн үндсэн шалтгааныг хянаж чадах, тохиролцсон арга хэмжээг хэрэгжүүлэх боломж дээр нь үндэслэнэ.

Аюулгүй байдал, бизнесийн ёс зүйд нөлөөлсөн осол зөрчлийн хувьд аюулгүй байдал, эрсдэл/бизнесийн ёс зүйн хэлтсүүд бүх осол, зөрчил, хариу арга хэмжээний удирдлагыг хариуцах ба холбогдох шууд удирдах ажилтнуудад мэдэгдэж, хамтран ажиллана.

### **4. ЖУРМЫН ДЭЛГЭРЭНГҮЙ**

#### **4.1. Эхний авах арга хэмжээ болон мэдэгдэх хугацаа: Шуурхай**

Хүний эрүүл мэнд, үйл ажиллагаа болон байгаль орчинд нэмж хор хөнөөл учруулж болзошгүй тохиолдлуудаас сэргийлэх үүднээс тухайн осол зөрчлийг даган үүсэж болзошгүй эрсдлүүдийг арилгах эсвэл бууруулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ. Үүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, асгарсан бодисын тархалтыг зогсоох, үйлдвэрийг түр хаах болон осол зөрчлийг хянаж зохицуулах гэх мэт бусад ажлууд багтаж болно. Нөхцөл байдал тогтворжмогц осол, зөрчил гарсан газрыг хамгаалж, хөндөлгүй үлдээх ажиллагааг эхлүүлэх шаардлагатай.

#### Анхны мэдэгдэл:

- Ноцтой осол зөрчил, гэмтэж бэртсэн тохиолдол болон бусад яаралтай байдлын үед ОТ төслийн талбайд байгаа бол: Үйл ажиллагааны хяналтын өрөө рүү радио холбоогоор, эсвэл ОТ Төслийн талбайн яаралтай тусламжийн +976 99043333 утсанд мэдэгдэх, Улаанбаатарт байгаа бол: +976 99061684 утас руу холбогдож мэдэгдэнэ. Шаардлагатай бол яаралтай тусламжийн арга хэмжээ авна.
- Бүх осол зөрчлийг гарсан даруйд нь (осолд дөхсөн тохиолдлыг оролцуулан) шууд удирдлагадаа (ахлах мэргэжилтэн хүртэлх албан тушаалтай хүнд) мэдэгдэнэ. Гэрээт ажилтан, компаниуд холбогдох ОТ удирдлагадаа мэдэгдэнэ.
- Осол зөрчлийн улмаас хүн бэртэж, гэмтсэн бүх тохиолдолд Төслийн талбайн эмнэлэг (Улаанбаатарт холбогдох эмнэлгийн байгууллага)-руу яаралтай мэдэгдэнэ.
- Асгаралттай холбоотой, зэрлэг ан амьтад, шувуу үхсэн, өвчилсөн тохиолдолд байгаль орчны хэлтэстэй нэн даруй холбогдоно. Осол болсон газарт ойртохгүй, эсвэл мал амьтанд хүрэлгүйгээр хэвээр нь орхиж, Байгаль орчны ажилтнуудыг ирэх хүртэл хүлээнэ. Асгаралт, зэрлэг ан амьтан, шувуу болон мал амьтантай холбоотой журмуудыг дараах баримт бичгүүдээс үзнэ үү:

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

- Зэрлэг амьтантай тааралдах үед баримтлах журам
- Биологийн олон янз байдлыг хамгаалах журам
- Асгаралтыг зохицуулах журам
- Амьд болон үхсэн амьтныг шилжүүлэх болон устгах АСЖ
- Орон нутгийн иргэдтэй холбоотой осол зөрчил гарсан болон орон нутгийн иргэдээс гомдол ирсэн тохиолдолд (зөвшөөрөгдөөгүй замаар зорчих, үхсэн болон өвчилсөн мал гэх мэт) Орон нутгийн хэлтэстэй даруй холбогдоно.
- Хувь хүний болон өмч хөрөнгийн аюулгүй байдалтай холбоотой осол зөрчил (золбин ноход үүнд багтана) гарсан бол Аюулгүй байдлын хэлтэстэй даруй холбогдоно.

#### **4.2. Осол зөрчил гарсан газрыг хамгаалалтад авах нь**

Осол, зөрчил болсон газарт нэн даруй хяналт тогтоосны дараа зохих шаардлага ёсоор хамгаалалтанд авч байгууллагын дотоод ажилтан, хөндлөнгийн талуудын аль алинд осол, зөрчлийг судлах боломжийг бүрдүүлнэ.

Үр дагаврын бодит дээд хэмжээ нь бага буюу дунд ангилалд багтаж буй, бодит хохирол нь хөнгөн болон дунд зэргийн ангилалд орох осол, зөрчлийн үед осол, зөрчлийн газрыг удаан хугацаагаар хамгаалалтанд авах боломжгүй байвал үйл ажиллагааг эргэн сэргээхээс өмнө тухайн газраас биет баримт нотолгоо цуглуулах ажил дээр бүх боломж бололцоогоо дайчилна.

Ямар нэг осолд зөрчилд шууд холбогдсон бүх хүнийг *Согтууруулах ундааны талаар баримтлах Оюу Толгой ХХК-ий бодлого*-ийн дагуу шалгана.

#### **4.3. Осол зөрчлийн ангилал – Ангилалыг тогтоох нь**

Тодорхой байгаа мэдээллийг үндэслэн анхны Осол зөрчлийн ангилалыг тогтоох үйл ажиллагаа явагдана.

- Бүх осол зөрчлийг (осолд дөхсөн тохиолдлыг оролцуулан) *ЭМААБО Эрсдлийн үнэлгээний 5x5 матриц (ОТ-03-СОМ-0009-М)*-ийг ашиглан 24 цагийн дотор ангилах ба үүнд дараах хүчин зүйлсийг харгалзана:
  - Бодит хохирол
  - Үр дагаврын бодит дээд хэмжээ (хохирлын болон магадлалын дээд хэмжээ)

Осол зөрчлийн нөлөө тус бүрт нь үнэлгээ хийнэ.

Энэхүү алхмаар тухайн осол зөрчлийг Ноцтой осол зөрчил, цаашлаад Болзошгүй ноцтой осол зөрчил эсэхийг тодорхойлно.

ОТ Осол зөрчлийн судалгаа, Осол зөрчлийн НО болон БНО ангилалууд (ОТ-14-СОМ-0011-М) баримт бичгээс лавлана уу.

- Ангилалыг тухайн ажлын хэсгийн ахлах мэргэжилтэн, ахлах ажилтан болон ЭМААБО-ны үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн (бусад удирдах ажилтнууд) нар хамтран тогтооно.
- Осол зөрчлийн анхны ангилалд үндэслэн түүнийг мэдээлэх болон судлах шаардлагуудыг тодорхойлно.

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

#### **4.4. Осол зөрчлийг бүртгэх, мэдээлэх**

Удирдах ажилтнууд гарсан осол, зөрчлийг ажлын ээлж солигдохоос өмнө (РТБШ-д) бүртгэх үүрэгтэй. Гэмтэл бэртлийн хувьд ОТ Эрүүл мэндийн баг (Эмнэлгийн үзлэгийн мэдээг хянасны дараа) бүртгэлийг гүйцээнэ.

Бүртгэлдээ дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Осол, зөрчил гарсан огноо, цаг, минут;
- Осол, зөрчил гарсан ажлын талбар (байрлал);
- Осол, зөрчлийг хариуцах хэлтэс, салбар;
- Холбогдсон хүмүүс;
- Болсон явдлын товч тайлбар;
- Осол зөрчлөөс үүдэн гарсан бүх нөлөөлөл (аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, байгаль орчин, орон нутаг, бүтгээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үйл явц болон/юмуу бизнесийн ёс зүй)

Осол, зөрчлийн талаарх бичвэр мэдээллийг (албан) Англи хэлээр, дараа нь Монгол хэлээр (албан бус) РТБШ-д бүртгэнэ.

Уг осол нь нутгийн иргэдтэй холбоотой бол ажлын талбар хариуцсан менежерт аль болох түргэн мэдээлнэ. Менежер дуудлага өгсөн хүнтэй тухайн ээлжийн хугацаанд эргэн холбогдож, дуудлагын мөрөөр авсан арга хэмжээний тайлбарыг өгнө. Боломжтой бол судлах болон хариу арга хэмжээ бүрэн авахад шаардагдах хугацааг тооцоолон, гаргаж мэдэгдэнэ.

#### **4.5. Осол зөрчлийг мэдэгдэх**

Осол, зөрчлийн үр дагаврын ноцтой байдлыг нэн даруй судлан тогтоож, зохицуулалт хийсний дараа шууд удирдлага болон ЕМ/Ахлах удирдлагад аль болох эрт амаар мэдэгдэнэ.

Анхны үнэлгээгээр Ноцтой болон Болзошгүй ноцтой осол зөрчил гэж тогтоогдсон тохиолдолд тухайн ажлын хэсгийн ЭМААБО-ны ахлах ажилтан ОТ ЭМААБО Харилцах шуудангийн хайрцагаас ОТ Төслийн талбайн удирдах ажилтнууд (ОТ Ахлах удирдлагуудад ослын анхны мэдээг хүргэх жагсаалт)-руу Осол зөрчлийн анхны мэдээний э-шуудан (ОТ-ТМР-0001-М) илгээнэ. Энэхүү мэдээг осол гарснаас хойш 4 цагийн дотор илгээнэ.

Анхны үнэлгээгээр Ноцтой болон Болзошгүй ноцтой осол зөрчил гэж тогтоогдсон, мөн Эмнэлгийн үйлчилгээ авсан болон түүнээс давсан тохиолдолд хэлтсийн Ерөнхий менежер/Ахлах удирдлага осол зөрчил гарснаас 24 цагийн дотор ГЕЗ, YAXE3 болон ЭМААБО-ны ЕМ нарт 24 цагийн тайланг (ОТ-14-FRM-0014-E-SI SPI Reportable Injury 24hour Report Form) илгээнэ.

Хүснэгт 1-д осол зөрчлийг мэдээлэх наад захын шаардлагыг харуулав.

Санамж:

- Гадагшаа харилцах шаардлагатай үед ОТ Хуулийн хэлтэстэй зөвшилцөнө (Төв ЭМААБО-ны багаар дамжуулан).
- Цагдаагийн байгууллагад мэдээ өгөх тохиолдолд ОТ ЭМААБО болон ОТ аюулгүй байдлын хэлтсүүдтэй зөвшилцөнө.

## Осол, зөрчлийн удирдлагын журам

Хочин тгдлр болох огноо:  
2014.03.01

Баримт бичгийн дугаар:  
ОТ-14-PRC-0001-М

Хувилбар:  
2.0

Осол, зөрчлийн төрөл	Хэзээ мэдэгдэх	Хэрхэн мэдэгдэх	Хариуцах албан тушаалтан	Хэнд мэдэгдэх
Бүх осол, зөрчил (осолд дөхсөн тохиолдол орно)	Нэн даруй	Амаар мэдэгдэнэ	Осолд холбогдогч Удирдах ажилтан	Шууд удирдлага Ахлах мэргэжилтэн, ЭМААБО-ны ахлах мэргэжилтэн
Яаралтай арга хэмжээ авах шаардлагатай осол, зөрчлүүд	Нэн даруй	Амаар мэдэгдэнэ	Осолд холбогдогч/Шууд удирдлага	Үйл ажиллагааны хяналтын өрөө
			Осолд холбогдогч/Шууд удирдлага	Үйл ажиллагаа хариуцсан Ерөнхий менежер
			Үйл ажиллагааны хяналтын өрөө	Аврах багийн ахлагч
	2 цагийн дотор	Амаар мэдэгдэнэ	Үйл ажиллагаа хариуцсан Ерөнхий менежер	Үйл ажиллагааны гүйцэтгэх захирал, Дэд ерөнхийлөгч, ЭМААБО-ны Ерөнхий менежер
Анхны үнэлгээгээр Ноцтой болон Болзошгүй ноцтой осол зөрчил гэж үнэлэгдсэн осол зөрчил (Анхны осол зөрчлийн мэдэгдэл)	4 цагийн дотор	Цахим шуудангаар мэдээлнэ	Ажлын хэсгийн ЭМААБО-ны ахлах ажилтан	Осол зөрчлийн анхны мэдэгдлийн и-мэйл (ОТ-14-TMP-0001-М) загвараар ОТ ЭМААБО-ны харилцах шуудангаас ОТ удирдах ажилтнуудын жагсаалт руу илгээнэ (ОТ Ахлах удирдлагууд + бүх ОТ ахлах мэргэжилтнүүд)
Бүх осол, зөрчил (Осолд дөхсөн тохиолдол орно)	Тухайн ээлжинд	РТБШ-ээс И-мэйлээр мэдэгдэх	Шууд удирдлага осол, зөрчлийг РТБШ-д бүртгэнэ	Байгууллагын салбар нэгжийн удирдах ажилтан Ажлын талбар хэсгийг хариуцагч Үйл ажиллагааны талбар дахь ЭМААБО-ны ахлах мэргэжилтэн, ЭМААБО-ны төвийн холбогдох менежер Бэртсэн хүний удирдах ажилтан (гэмтэл бэртэл) Эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжилтэн (гэмтэл бэртэл) Жич: Тусгайлан заасан бусад салбар хэлтэс)
Анхны үнэлгээгээр НО/БНО гэж тогтоогдсон, мөн эмнэлгийн үйлчилгээ авсан болон түүнээс давсан тохиолдол	24 цагийн дотор	НО/БНО/Мэдэгдвэл зохих гэмтэл бэртлийн 24 цагийн тайлан	Хэлтсийн ЕМ/Ахлах удирдлага	ГЕЗ, ҮАХЕЗ болон ЭМААБО-ны ЕМ нарт и-мэйл илгээх (Загвар: ОТ-14-FRM-0014-E-SI SPI Reportable injury 24hour report form)
Онц ноцтой (Ж: Нэг хүн эндэх) буюу гамшгийн хэмжээний (Ж: Олон хүн эндэх) (24 цагт мэдээлэх РТ-н шаардлага) бодит хохиролтой бүх осол, зөрчил	24 цагийн дотор	Амаар мэдэгдэж, бичгээр мэдээлэх	Оюу Толгойн Гүйцэтгэх ерөнхий захирал	Рио Тинтогийн Гүйцэтгэх Захирал Зэсийн бүтээгдэхүүний группын тэргүүн ЭМААБООН-ийн асуудал хариуцсан тэргүүн Аюулгүй байдал хариуцсан тэргүүн
Ноцтой болон болзошгүй ноцтой бүх осол, зөрчил	48 цагийн дотор	ЭМААБО-ны урьдчилсан сэрэмжлүүлэг	ЭМААБО-ны Ерөнхий менежер	Бүх ажилтан (“ОТ-н бүх хэрэглэгч”, ОТ Гэрээлэгчдийн аюулгүй байдлын ажилтны жагсаалтууд руу)
	10 өдрийн дотор	Осол, зөрчлийг шалгасан тайлан, дүгнэлт	Ахлах шинжээч	Тухайн хэлтсийн үйл ажиллагааны удирдах ажилтнууд Осол, зөрчлийг хянан үзэх долоо хоног тутмын уулзалт
Гэмтэл бэртэл гарсан осол зөрчил – ажилтны гэмтэл болон ажилд учирсан хохирлыг хэлэлцэх	2 өдрийн дотор	Амаар болон цахим шуудангаар мэдэгдэх	Эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Удирдах ажилтан ЭМААБО-ны ахлах мэргэжилтэн
Гадны байгууллагад мэдэгдэх шаардлагатай осол буюу үйлдвэрлэлийн осол, хурц хордлого	Нэн даруй	Амаар буюу 5.2 дахь зүйлд зааснаар Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг яаралтай мэдэгдэх маягтаар (14-р тогтоолын 2-р хавсралт) мэдэгдэх.	Үйлдвэрлэлийн ослын комисс (Төслийн талбайн аюулгүй ажиллагааны менежер даргална)	Монгол улсын холбогдох байгууллага (ОТ-14-PRC-0011-М) ОТ чиг хандлага – Засгийн Газрын 14-р тогтоол Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг сахиж мөрдөх)
Гадны байгууллагад мэдэгдэх шаардлагатай осол буюу үйлдвэрлэлийн осол, хурц хордлого	3 өдрийн дотор	Үйлдвэрлэлийн ослын акт (загварын дагуу)	Үйл ажиллагааны ЭМААБО-ны ахлах мэргэжилтэн	Монгол улсын холбогдох байгууллага (ОТ-14-PRC-0011-М) ОТ чиг хандлага – Засгийн Газрын 14-р тогтоол Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг сахиж мөрдөх)
Амьтан бэртсэн буюу үхсэн			TBC	Амьд болон үхсэн амьтныг шилжүүлэх болон устгах АСЖ-аас үзнэ үү
БОННУ-ний дагуу мэдэгдэх шаардлагатай осол зөрчил (амь нас эндэх болон байгаль орчин, орон нутгийн иргэдэд ноцтой нөлөөлөх осол зөрчил багтана)	TBC	Осол зөрчлийн тойм	БОННУ-ний тохирлын мэргэжилтэн	Зээлдэгчдийн БОННУ-ний төлөөлөл

Хуудас 6, Нийт 16

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СӨЛЖИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ ХУУДАСНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2014-04-30

<b>Осол, зөрчлийн удирдлагын журам</b>		
Хочин тгд болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

#### 4.6. Ослын судалгаа хийх түвшин болон аргачлал

Осол зөрчлийн ангилалаас хамааран осол зөрчил гарснаас хойш 10 хоногийн дотор судалгааг явуулна (бодит үр дагавар болон ҮДБДХ гэх мэт).

Осол зөрчил гарсан хэсгийг хариуцсан удирдах ажилтан (ахлах мэргэжилтэн болон түүнээс дээш албан тушаалтай хүн, эсвэл гэмтэж бэртсэн хүний шууд удирдлага болон осол зөрчил гарсан талбарыг хариуцсан хүн) нь ахлах шинжээчийг томилох ба тохирсон цаг хугацаанд зохих түвшний судалгааг хийлгэх үүргийг хүлээнэ. Удирдах ажилтан нь судалгааг энэхүү журамд нийцүүлэн хийх болон удирдах ажлыг хариуцна.

Тухайн осол, зөрчлийн ангилалд тулгуурлан судалгаа шинжилгээ хийх түвшинг тодорхойлно. Хүснэгт 2-д судалгаа хийхэд тавигдах хамгийн доод шаардлага, гүйцэтгэж дуусгах хугацааг заав.

Хүснэгт 2 Судалгаа шинжилгээнд тавигдах хамгийн доод шаардлага

Осол, зөрчлийн ангилал	Ослын судалгааны аргачлал	Ослын судалгааг дуусгах хугацаа	Ахлах шинжээч
Бодит үр дагавар: “Ноцтой” (хязгаарлагдсан ажлын өдөр орохгүй), “Онц ноцтой”, “Гамшгийн”	Үр дүнтэй судалгаа хийх 8 алхам (Гол хүчин зүйлийг судлах арга) (Гол хүчин зүйлийн судалгааг ТапРүүт шатлалтай зэрэгцүүлэх)	10 хоногт	Сургагдсан зохицуулагч (хэлтэст хамаарахгүй – (ж.нь өөр алба хэлтсийн менежер))
Үр дагаврын бодит дээд хязгаар	Үр дүнтэй судалгаа хийх 8 алхам (Гол хүчин зүйлсийн судалгааны арга)	10 хоногт	Сургагдсан зохицуулагч (хэлтэст хамаарахгүй – (ж.нь өөр алба чиглэлийн менежер))
Бусад бүх осол, зөрчил	Заавал шаардагдах аргачлал байхгүй – дараах зүйлсийг тодорхойлно: <ul style="list-style-type: none"> <li>Ослын ерөнхий үйл явц</li> <li>Урьдчилан сэргийлэхийн тулд авах арга хэмжээг тодорхойлох</li> <li>Бодит үр дагавар болон ҮДБДХ-г баталгаажуулах</li> <li>Засах болон урьдчилан сэргийлэх (шаардлагатай бол) арга хэмжээг хэрэгжүүлнэ</li> </ul>	7 хоногт	Шууд удирдлага (ахлах ажилтан)

Осол зөрчлийн судалгаа болон осол зөрчлийн НО, БНО ангилал (ОТ-14-COM-0011-М-ОТ) баримт бичгээс лавлана уу.

Бодит үр дагавар нь *Онц ноцтой болон Гамшгийн* байгаа тохиолдолд Ахлах шинжээчийг Рио Тинтогоос томилно.

Монгол улсын Засгийн газрын 14-р тогтоолын хавсралт Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн 2.7 болон 2.10 заалтуудаас амь нас эрсэдсэн болон ихээхэн хэмжээний хохирол бүхий ноцтой үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын судалгаанд тавиглах шаардлагуудыг харна уу.

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

#### **4.7. Ослын судалгаа хийх баг – Ахлах шинжээчийг сонгох**

Осол, зөрчлийн судалгаа хийх бүрт ахлах шинжээчийг томилно. Томилогдох хүн ослын шинжилгээ хийх ур чадвартай бөгөөд сонгогдсон судалгааны аргачлалыг ашиглахад суралцсан байна

Хариуцагч менежер ахлах шинжээчийг томилохдоо дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- Тухайн ослын судалгааны аргачлалын сургалтанд хамрагдсан байдал
- Бие даасан байдал
- Ур чадвар, үйл ажиллагааны мэдлэг болон судалгаа хийх чадвар
- Эрх мэдлийн түвшин
- Осол зөрчлийн шинж чанараас хамааран түүнд тохирох мэргэжлийн ур чадвар
- Хууль эрхзүйн шаардлага

Ахлах шинжээч судалгааны үйл явцын талаар Менежерт тогтмол мэдээлнэ. Шаардлагатай тохиолдолд (захиргааны аргаа хэмжээ авах буюу Амь нас хамгаалах дүрэм зөрчигдсөн бол) Менежер судалгааны явцын талаарх мэдээллийг хүний нөөцөд өгнө.

Онц ноцтой болон гамшгийн бодит үр дагавар бүхий осол зөрчлийн судалгааны ажлын ахлах шинжээчээр Ерөнхий менежерийн албан тушаалтай хүн ажиллах ба Гүйцэтгэх ерөнхий захирал болон Үйл ажиллагаа эрхэлсэн ерөнхий захирал түүнийг томилно.

Аюулгүй байдал, бизнесийн ёс зүйд нөлөөлөх осол, зөрчлийн ахлах шинжээч тус салбар чиглэлийн мэргэжилтэн байна.

#### **4.8. Ослын судалгаа хийх баг – Багийн гишүүдийг сонгох**

Ахлах шинжээчийг томилсны дараа доорх шалгуурт тулгуурлан осол зөрчлийн судалгааны багийн гишүүдийг бүрдүүлнэ:

- Ур чадвар, туршлага, үйл ажиллагааны талаарх мэдлэг
- Гарсан ноцтой осол, зөрчил нь ЭМААБО-ы үйл ажиллагааны гүйцэтгэлийн стандарттай холбоотой бол тухайн стандартыг хариуцагч манлайлагч/ахлагчдын багийн гишүүнийг оролцуулах шаардлагатай.
- Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны мэргэжилтнүүд
- Гэрээт гүйцэтгэгчид осол, зөрчилд холбогдсон бол тухайн гүйцэтгэгч компанийн төлөөлөл
- Шаардлагатай бол дотоод, гадаад оролцогч талуудын төлөөлөл
- Осол, зөрчлийн мөн чанарт тохирсон мэргэжлийн ур чадвартай байх. Зарим осол, зөрчлийн үед (цахилгаан, агаарын тээврийн гэх мэт) хуульд шаардлага болгосны дагуу байгууллагад зайлшгүй байх ёстой ажил үүрэгт томилогдсон ажилтнууд болон гадны зөвлөхүүдийг оролцуулах талаар авч үзэх шаардлагатай.
- Онц ноцтой болон Гамшгийн үр дагавар учруулсан осол, зөрчлийг судлан шинжлэх багийн гишүүдээс доод тал нь нэг гишүүн нь тухайн үйл ажиллагаанд хамааралгүй байна. Ахлах шинжээч, мөн судалгаа шинжилгээний багт хууль зүйн зохих зөвлөгөө авах бүрэн боломжийг бүрдүүлж өгнө.



<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

#### **4.9. Судалгааг явуулах: Осол зөрчлийг ойлгох нь**

Судалгаанд Хүрээлэн буй орчин, Тоног төхөөрөмж, Хүмүүс гэсэн хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай. Дараах баримт бичгүүдийг ашиглаж болно:

- Алхам бүр дэхь Ахлах шинжээчийн шалгах хуудас - ОТ-14-GDL-0007-М- 8 Алхам – Гол хүчин зүйлийн судалгааны 1-8-р алхам
- Судалгааны мэдээллийн баримтжуулалт - ОТ-14-TMP-0013-М- 8 Алхам Судалгааг дэмжих хэрэглүүр эсвэл ОТ-14-TMP-0012- 8 Алхам – Үнэлгээ ба Хяналтыг тодорхойлох нь – Гол хүчин зүйлийн маягт
- Сургалтын материал: Осол зөрчлийг үр дүнтэй судлах 8 Алхам (Осол зөрчил болон гол хүчин зүйлийг ойлгох нь)
- Амь нас хамгаалах дүрэм зөрчсөн осол зөрчил: Амь нас хамгаалах дүрэм зөрчигдсэн тохиолдолд мөрдөх журам (ОТ-01-PRC-0002) болон шалгах хуудсыг ашиглана. Амь нас хамгаалах дүрэм зөрчигдсэн тохиолдлын судалгааны шалгах хуудсыг (ОТ-14-FRM-0012) судалгааны явцад заавал бөглөх шаардлагатай. .
- Согтууруулах ундаатай холбоотой осол зөрчил: Согтууруулах ундаатай холбоотой мөрдөх журам болон Согтууруулах ундаатай зөрчлийг шалгах хуудсыг ашиглана (ОТ-14-FRM-0013). Шалгах хуудсыг судалгааны явцад заавал бөглөх шаардлагатай.

##### **4.9.1. Алхам 1: Судалгааны хамрах хүрээг тодорхойлж, бэлтгэх:**

Судалгааг эхлэхийн өмнө хамрах хүрээг судалгааны төрөл болон түвшинтэй уялдуулан албан ёсоор тодорхойлно.

Хамрах хүрээг тодорхойлох нь үйл явдлын дарааллын эхлэх болон дуусах цэгийг тогтоох, нотлох баримтын шаардлагатай хэмжээг тодруулах зэрэгт тус болдог. Жишээлбэл, ноцтой осол зөрчил гарсан үед нотлох баримтын түүх болон үйл явдлын үе шатууд нь осол болохоос нэг жил, түүнээс ч их хугацаагааны өмнөх үед очиж болно.

Энэ алхамд гол авах арга хэмжээ нь

- Баг, харилцагчдийг бүрдүүлэх (хамрах хүрээг тохирох үүнд багтана)
- Материал бэлтгэл (судалгааны хэрэгслийн багц үүнд багтана). Судалгааны хэрэгсэл болон багажуудыг мэдээлэл цуглуулахад ашиглана (тухайн хэсгийн судалгааны хэрэгслийн багцийг ашиглана. *Осол зөрчлийн судалгааны бэлтгэлийн шалгах хуудас (ОТ-14-TMP-0011-М)*-аас лавлана уу.
- Багийн бүрэлдэхүүн эхний уулзалтыг хийх

##### **4.9.2. Алхам 2: Мэдээлэл/баримт цуглуулах**

Байгаль орчин, Тоног төхөөрөмж, Хүмүүстэй холбоотой бүх баримт мэдээллийг тодорхойлж, багийн гишүүдэд цуглуулах мэдээллийг хуваарилна. Судалгааны үеэр энэхүү жагсаалтад нэмэлт мэдээлэл оруулж болно.

Амь насаа хамгаалах дүрмийг зөрчсөн тохиолдолд: Амь насаа хамгаалах дүрмийг зөрчсөн тохиолдолд мөрдөх журам (ОТ-01-PRC-0002) болон шалгах хуудсаас лавлана уу.

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

Судалгааны хүрээнд Амь насаа хамгаалах дүрмийг зөрчсөн тохиолдлыг судлах хуудас (ОТ-14-FRM-0012)-ыг бөглөнө.

Согтууруулах ундаатай холбоотой осол зөрчил гарсан тохиолдолд: Согтууруулах ундааны талаар баримтлах бодлого болон Согтууруулах ундаатай холбоотой осол зөрчлийг шалгах хуудас (ОТ-14-FRM-0013)-ыг лавлана уу. Шалгах хуудсыг судалгааны нэг хэсэг болгон бөглөнө.

#### **4.9.2.1. Осол зөрчлийн талбарын үзлэг**

- Судалгаа шинжилгээний баг (бүрэн бүрэлдэхүүнээр) осол, зөрчил гарсны дараа аль болох түргэн хугацаанд тухайн осол, зөрчил гарсан газарт үзлэг хийх ёстой. Үзлэг шинжилгээг хараахан хийгээгүй тохиолдолд боломжийн хэрээр тухайн газрыг хамгаалж, бусад хүнд учруулж болзошгүй гэмтэл бэртлээс сэргийлэн, баримт нотолгоог хамгаалах арга хэмжээ авна.
- Осол, зөрчлийн газрын үзлэг шинжилгээний өмнө ажил эхлэхийн өмнөх аюул эрсдлийн үнэлгээг (УХААН, ААДШ) хийж, хяналтын арга хэмжээ авна. Ахлах шинжээч шаардлагатай бол судалгаа шинжилгээний багийг зохих хүмүүсээр дагалдуулж, багийнхаа бүх гишүүнийг тухайн ажлын талбарт сахин биелүүлэх ёстой хувийн хамгаалалтын хэрэгсэл (ХХХ) ашиглах шаардлагыг мөрдүүлнэ.

#### **4.9.2.2. Цуглуулах баримт нотолгоо**

Судалгааны үеэр цуглуулах баримт нотолгоонд дараах зүйлс багтана:

- Осол зөрчил гарсан газарт үзлэг хийх үеийн фото зураг (Осол зөрчлийн судалгааны фото бүртгэл ОТ-14-TMP-0007-D), дээж, орчин тойрны мэдээлэл, газрын зураг, зураглал гэх мэт
- Мэдээлэл цуглуулах үед: Эвдэрч гэмтсэн хэсэг, материалын шалгалт үнэлгээний мэдээлэл, журам (АСЖ), зааварчилгаа, сургалтын бүртгэл, үзлэг болон засвар үйлчилгээний бүртгэл
- Хувь хүнтэй хийсэн ярилцлага (Осол зөрчлийн судалгааны ярилцлагын хуудас (ОТ-14-TMP-0009-D)). Ярилцлагыг бие даасан хүн явуулах шаардлагатай. Сахилгын арга хэмжээ авах боломжтой осол зөрчлийн хувьд энэ тухай мэдэгдлийг ярилцлагын үеэр сануулж хэлнэ.

#### **4.9.2.3. Нууцлал**

- Судалгааны үед болон баримтжуулах үеэр гэмтсэн/өвчилсэн хүний хувийн нууцыг хадгалах зарчим баримтална. Бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг задруулж болохгүй ба эрүүл мэндийн нарийн мэдээллийг осол зөрчлийн судалгааны багийн хүрээнд хадгалж, гадагш задруулахгүй.
- Осол зөрчлийн бүртгэлд багтах гэмтэл/өвчлөлийн мэдээлэлд эмнэлгийн бус мэдээллийг багтаана (ж.нь. ангилал, биеийн хэсэг, гэмтлийн төрөл, алдагдсан болон хязгаарлагдсан өдөр).
- Осол, зөрчилтэй холбоотойгоор боловсруулах бүх баримт бичгийн нууцлалын зэрэг болон тус мэдээллийг ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах хүмүүс зэргийг анхааран авч үзнэ.

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

#### **4.9.3. Алхам 3: Таамаглал гаргаж, турших**

Энэ шатанд судалгааны баг осол зөрчлийн шалтгааныг юу үүсгэсэн байх боломжтойг тодорхойлж, эцсийн таамаглалуудаа гаргана.

Таамаглал бүрийн хувьд түүнийг батлаж буй болон үгүйсгэж буй ажиглалтуудыг тодорхойлно.

##### **4.9.3.1. Үйл явдлын дарааллыг тогтоох:**

- Цуглуулсан мэдээлэл болон нотлох баримтад тулгуурлан үйл явдлын дарааллыг тодорхойлно. Ингэхдээ осолд зөрчилд хүргэсэн болон түүний дараа болсон үйл явдлыг баримтад үндэслэсэн, үнэн зөв байдлаар дүрслэнэ. Үйл явдлын дарааллын үргэлжлэх хугацаа нь боловсруулсан судалгааны хамрах хүрээгээр тодорхойлогдоно.
- Дараалал нь осол зөрчлийн дараах үе шатуудыг тодорхойлно: “Өдөөгч хүчин зүйл>Тогтворжсон> Хагас тогтворжсон>Тогтворгүй>Хохирол>Засварт өгөх>Засварлах>Тогтворжсон” ( Үр дүнтэй судлах 8 алхам ART-T™-ээс лавлана уу).

##### **4.9.3.2. Дутуу мэдээллийг олж тогтоон, цуглуулах:**

- Үйл явдлын дарааллыг тогтоох нь дутуу буюу батлагдаагүй байгаа мэдээллийг тодруулахад дөхөм болдог. Цуглуулах, бататгах шаардлагатай баримт нотолгоог олж тодорхойлон, тус ажлыг гүйцэтгэх үүргийг шинжилгээний багийнханд даалгана.
- Нэмэлт мэдээллийг цуглуулж, батлагдаагүй мэдээллийг баталгаажуулсан зэрэг тохиолдолд тэдгээрийг бүгдийг үйл явдлын дараалалд нэмж оруулах ба энэ үйл явц бүх шаардлагатай мэдээллийг тусгасан гэж шинжилгээний баг үзэх хүртэл үргэлжилнэ.

#### **4.9.4. Алхам 4: Осол зөрчлийн тайлбарыг бичих**

Осол зөрчлийн тайлбар нь осол зөрчлийн тухай бүх баримтжуулсан мэдээллийг өгнө. Үүнд: Хэн, Юу, Хэзээ, Хаана, Яагаад, Хэрхэн агуулгуудыг багтаана.

Мөн харилцах, бүрэн ойлгох болон шинжилгээний чанарыг сайжруулахад ашиглагдана.

Ноцтой бус осол зөрчлийн хувьд шууд Алхам 8: Зөвлөмж болон авах арга хэмжээг тодорхойлох, осол зөрчлийг баримтжуулах, хянах алхам руу очно уу.

Ноцтой осол зөрчлийн хувьд: Шинжилгээ хийх 5 дугаар алхам руу очно.

#### **4.9.5. Алхам 5: Гол хүчин зүйлсийн шинжилгээг хийх**

Энэ шатанд судалгааны баг дараах зүйлсийг тодруулна

- Осол зөрчилтэй холбоотой нөхцөл байдал
- Тоног төхөөрөмж, Хүрээлэн буй орчин, Хүмүүс гэсэн элементүүдийн жагсаалт.
- Элемент тус бүрийн Байгаа болон байхгүй хүчин зүйлсийг тодорхойлж (IS/IS NOT) аль нь **Гол** аль нь **Туслах** болохыг үнэлнэ. Дараах асуултуудыг асуух шаардлагатай:
  - Хүрээлэн буй орчин/тоног төхөөрөмжийн ердийн шинж чанарууд хэвэндээ байгаа, эсвэл байхгүй эсэх
  - Хүмүүс: мэдсэн, мэдээгүй, байсан, байгаагүй гэх мэт

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

#### **4.9.6. Алхам 6 – Хянах боломжтой хүчин зүйлсийг тодорхойлж, хураангуйлах**

Гол болон туслах хүчин зүйлсийн хянах боломжтой хэсгүүдийг тодорхойлно.

#### **4.9.7. Алхам 7 – Хянах боломжтой өдөөгч хүчин зүйлсийг тодорхойлох**

Хүчин зүйл тус бүрийн хянах боломжтой өдөөгч хүчин зүйлсийг тодорхойлно. Үүнд осол зөрчил гарахад чухал нөлөө үзүүлсэн зүйлс (байгууллага, журам гэх мэт) багтана.

##### **4.9.7.1. Алхам 7б – Гол хүчин зүйлсийг TapРүүт (TapRoot©) Шатлал руу шилжүүлнэ**

Энэ алхамд Бодит үр дагавар нь ноцтой (хязгаарлагдмал ажлын өдрийг оролцуулахгүй), онц ноцтой, гамшгийн гэж ангилагдсан бол TapРүүт (TapRoot©) Шатлал руу шилжүүлнэ. Судалгаа шинжилгээгээр цуглуулсан мэдээллийг TapРүүт Шалтгааны үндсэн шатлалтай харьцуулж, TapРүүт Шалтгааны хүчин зүйлсийг тодорхойлно. Дээрх ажлыг TapРүүт сургалтад хамрагдсан эрх бүхий хүн гүйцэтгэнэ.

#### **4.9.8. Алхам 8 – Зөвлөмж, авах арга хэмжээг тодорхойлох**

Судалгааны үеэр судалгааны баг нь нэмэлт хяналт болон ахин гарахаас сэргийлэх шаардлагатай хэсгүүдийг тодорхойлсон байх ба – эдгээр нь зөвлөмж боловсруулах үндэс болж өгнө (жишээ нь Алхам 6 болон 7). Зөвлөмжийг боловсруулахдаа хэрэгжих боломжтой, хүрч болохуйц, зохистой, тохиромжтой мөн тогтвортой байлгахад анхаарна.

Зөвлөмжийг хянасны дараа (осол зөрчлийг хариуцагч) хариу арга хэмжээг тодорхойлно.

РТБШ-д оруулахын өмнө арга хэмжээнүүдийг бүртгэхэд *Хариу арга хэмжээний маягт (ОТ-14-FRM-0011-D)*-ийг ашиглаж болно. Осол, зөрчлийн шалтгааныг тогтоох шинжилгээний дараах засаж залруулах ажиллагааг РТБШ-д бүртгэх, удирдан зохицуулах ажлыг “Осол, зөрчлийн удирдлагын журам: Хариу арга хэмжээний удирдлагад (ОТ-14-PRC-0009-М) тусгасан шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

Нөлөөлж буй хүчин зүйл нь одоо оршин байгаа аюул, эрсдэл гэж тогтоогдсон тохиолдолд *Эрсдлийг илрүүлэх болон Эрсдлийн удирдлагын Журам (ОТ-03-PRC-0001-М)* баримт бичигт тусгагдсан хяналтын аргын шатлал болон бусад тавигдах шаардлагыг ашиглаж, эрсдлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

#### **4.10. Осол зөрчлийн талаар баримт бичгийг хөтлөх**

Бүх осол зөрчлийг РТБШ-д бүртгэнэ. Ингэхдээ бөглөх шаардлагатай бүх хэсгийг бөглөж, эргэж хянах зорилгоор нотлох баримт болон бүртгэлийг хавсаргана. Түр ашиглах зорилгоор хэвлэмэл маягыг ашиглаж болно.

Ноцтой болон Болзошгүй ноцтой осол зөрчлийн хувьд Ахлах шинжээч эдгээрийг заавал гүйцэтгэж, тухайн хэлтсийн Ерөнхий менежер, Ахлах удирдлага болон ОТ ЭМААБО-оор хянуулан, батлуулна.

- Тайлан - *Осол зөрчлийн судалгааны тайлангийн загвар (ОТ-14-TMP-0003-М)*
- Дүгнэлт илтгэл - *Осол зөрчлийн судалгааны дүгнэлтийн загвар (ОТ-14-TMP-0005-М)* – харилцах мэдэгдэх шалтгаанаар дүгнэлт шаардлагатай бол.

Зохимжтой бол эдгээр загварыг бусад судалгааны үеэр ашиглаж болно

Хуудас 12/Нийт 16

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СӨСЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ

ХУУДАСНААС ХАРНА УУ

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2014-04-30

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

Осол зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг РТБШ-д бүртгэж, түүнийг бүртгэлийг хөтлөх ба үүнд дараах зүйлсийг тусгана:

- Осол зөрчлийн агуулга: гол мэдээлэл (огноо, цаг минут, ажлын талбар)
- Холбогдсон хүмүүс: осол зөрчилд холбогдсон хүмүүсийн жагсаалт.
  - Осол зөрчилтэй холбогдуулан бүх үндсэн болон гэрээт ажилтнуудын нэрсийн бүртгэлийг хадгална
  - Ахлах шинжээч осол зөрчлийн талаарх мэдүүлгэд үндэслэн осол зөрчлийн тайлбар дүгнэлтийг бичиж тэмдэглэнэ.
  - Монгол улсын хууль хяналтын байгууллагатай ямар нэг байдлаар харилцах тохиолдолд тухайн байгууллагын нэр, холбогдох хүний бүртгэлийг хадгалж, эргэн холбогдох зорилгоор ашиглана. Тухайн осол зөрчил нь нууцын зэрэглэлд багтах бол (аюулгүй байдал, нутгийн иргэд болон бизнесийн ёс зүйтэй холбоотой) ерөнхий шинжээчийн болон холбогдох хүмүүсийн мэдүүлгийг бүртгэл тэмдэглэлд оруулж, нэвтрэх эрхгүй хүмүүст хаалттай байлгана.
- Ерөнхий мэдээлэл: аюул ослын судалгаа шинжилгээнд дэм болох үүднээс осол, зөрчилд холбогдсон авто тээврийн хэрэгсэл болон аюулуудын талаарх мэдээллийг бүртгэл тэмдэглэлд оруулна.
- Нөлөөлөл: нөлөөллийн талаарх мэдээллийг тухайн талбарын баримт, мэдээллийн хэсэгт бүртгэж тэмдэглэнэ
- Үндсэн шалтгаан: судалгаа болон учир шалтгааны хүчин зүйлсийг дарцаглах буюу тодруулна.
- Арга хэмжээ: бүх хариу арга хэмжээ нь осол зөрчилтэй холбогдолтой байна. Илрүүлсэн шалтгааны хүчин зүйл бүрт дор хаяж нэг засах / урьдчилан сэргийлэх арга хэмжээг РТБШ-д оруулна. Тухайн асуудал, учруулсан нөлөөллийн хэр хэмжээнд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлнэ. *Осол зөрчлийн мөрөөр авах хариу арга хэмжээний удирдлага (ОТ-14-PRC-0009-М)* баримт бичгээс үзнэ үү.
- Гэмтэл бэртэл/өвчин: Гэмтэж бэртсэн юмуу өвчилсөн бүх хүнийг осол, зөрчилтэй холбож, шаардлагатай мэдээллийг хадгалан, хөтөлнө.
- Хавсралт баримт бичгүүд: судалгаатай холбоотой шинээр боловсруулсан болон түүнд оруулсан бүх баримт бичгийг осол зөрчлийн бүртгэлд хавсаргана.

Осол, зөрчлийн судалгааны явцыг осол зөрчлийн судалгааны төлөв байдлыг ашиглан хянана.

<b>Төлөв байдал</b>	<b>Тайлбар</b>
Эхэлсэн	Зайлшгүй шаардлагатай эхний бүх хэсэгт осол, зөрчлийн шинжилгээг эхлүүлж, холбогдох талуудыг оруулж, нөлөөллийг эхний байдлаар тодорхойлно.
Үргэлжилж буй	Осол, зөрчлийн шинжилгээ үргэлжлэх шатандаа явж буй. Нэмэлт мэдээллийг оруулж, осол, зөрчлийн зэрэглэлийг тодорхойлно. Судалгаа шинжилгээ үргэлжлэх бөгөөд гэмтэл бэртэл буюу өвчний талаарх мэдээллийг бичиж тэмдэглэнэ.
Судалгаа шинжилгээ дууссан	Осол, зөрчлийн судалгаа шинжилгээ дуусна. Бүх мэдээллийг нэмж оруулан, судалгаа шинжилгээний ажлыг баримт бичгээр

## Осол зөрчлийн удирдлагын журам

Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0
---	--	------------------

	баталгаажуулна. Судалгаа шинжилгээнд гарын үсэг зурж баталгаажуулах шаардлагатай бүх оролцогч талыг тодорхойлно. Арга хэмжээг тодорхойлсон бөгөөд хэрэгжүүлж эхэлсэн. Гэмтэл бэртэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.
Зөвлөгөөн	Менежер осол, зөрчлийг эцэслэн хянан үзэж, хаахад бэлэн болно. Хянан үзэж, гарын үсгээр баталгаажуулна.
Хаасан	Осол, зөрчлийг хаана. Мэдээллийг нь өөрчилж болохгүй боловч осол, зөрчлийг дахин нээж болно. <ul style="list-style-type: none"> <li>• Бүх холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж дуусна</li> <li>• Судалгаа шинжилгээг хийсэн, бүртгэл тэмдэглэлд оруулсан</li> <li>• Бэртэж гэмтсэн буюу өвчилсөн бүх тал ажилдаа эргэн орж, үүргээ бүрэн гүйцэтгэдэг болсон (боломжтой бол)</li> </ul>

### 4.11.Осол зөрчлийг хянан шалгах, гарын үсгээр баталгаажуулах, хаах

Судалгаа болон хариу арга хэмжээ бүрэн дууссаны дараа (гэмтэж бэртсэн хүн ажилдаа эргэж орсон) РТБШ дэхь осол зөрчлийн бүртгэлийг хянаж, гарын үсгээр баталгаажуулан хаана.

Осол зөрчлийг хянан шалгах, гарын үсгээр баталгаажуулах

Гарын үсгээр баталгаажуулах дараалал	Албан тушаал	Эрүүл мэнд	Аюулгүй ажиллагаа	Байгаль орчин	Орон нутаг	Үйл явц	Аюулгүй байдал	Чанар	Бизнесийн ёс зүй
1 Бүх осол, зөрчил	Ахлах мэргэжилтэн (эсвэл Ахлах шинжээч)	x	x	x	x	x		x	
Ноцтой, болзошгүй ноцтой осол, зөрчил	ЭМААБО-ны ерөнхий менежер Үйл ажиллагааны ерөнхий менежер	x	x	x	x	x		x	
Осол, зөрчил	Аюулгүй байдал буюу эрсдэл хариуцсан Ахлах ажилтан						x		x
Осол, зөрчил	Аюулгүй байдал буюу эрсдэл хариуцсан Дэд ерөнхийлөгч						x		x

Дараах зүйлсийг гүйцэтгэж, РТБШ-д мэдээллийг оруулах хүртэл (“Ослын судалгаа дууссан” гэсэн төлөвт) осол, зөрчил нээлттэй байна. Үүнд:

- Бүх арга хэмжээг хэрэгжүүлж дуусган, хэрэгжүүлсэн арга хэмжээний бүртгэл тэмдэглэлийг шинэчилсэн. Хариуцсан менежер нь тэдгээр арга хэмжээ нь зорьсон үр дүндээ хүрсэн эсэхэд хяналт тавьж, хангаж ажиллана;
- (Хамааралтай тохиолдолд) Тус гэмтэл бэртэл буюу өвчний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдсан буюу ажил үүрэг хязгаарлагдсан өдрүүдийн талаарх тоо баримтыг оруулан

<b>Осол зөрчлийн удирдлагын журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0

гэмтэл бэртэл буюу өвчний бүртгэл мэдээллийг хийж дуусган шинэчилсэн. Эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжилтэн баталгаажуулах шаардлагатай.

- (Хамааралтай тохиолдолд) Бэртэж гэмтсэн буюу өвчилсөн бүх тал ажил үүргээ дахин бүрэн гүйцэтгэж эхэлсэн буюу бэртэл гэмтэл, өвчнийг ажиглан судлах шаардлагагүй болсон. Үүнийг эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжилтэн баталгаажуулах шаардлагатай;
- Ослын судалгааны мэдээллийг бүрдүүлж дуусган, бүртгэн тэмдэглэсэн. Хариуцсан менежер судалгаа шинжилгээг зохих ёсоор хийлгэсэн байна. Осол, зөрчлийн талаарх судалгааны мэдээлэл болон ахлах шинжээчийн мэдүүлэг онцгой ач холбогдолтой.

Осол зөрчил болон хариу арга хэмжээний явцыг РТБШ тайлан ашиглан явуулна.

Дээрх арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэний дараа *Осол, зөрчил* “Зөвлөгөөн” төлөв рүү шилжинэ. Зөвлөгөөн нь хянан шалгах үйл явцыг эхлүүлэх бөгөөд тухайн үүргийг гүйцэтгэхээр тогтоогдсон бүх хүн хянан шалгах ажилд дэмжлэг болох ажлын жагсаалт хүлээж авна. Тэд хийсэн хяналт шалгалтынхаа талаарх тайлбарыг баримт бүртгэлд оруулж болох бөгөөд ажлыг дуусгасан гэсэн тэмдэглэгээ нь дараагийн хянагчид мэдэгдэлээр ирнэ.

Эцсийн хянагчаар томилогдсон хүн хяналт шалгалт дууссан болохыг бүртгэж тэмдэглэснээр осол, зөрчлийн төлөв “Зөвлөгөөн”-өөс “Хаагдсан” төлөв рүү шилжинэ.

## **5. Сургалт, ур чадвар**

Осол зөрчлийн удирдлагын журам: Сургалт, Нэр томъёо тодорхойлолт болон холбогдох баримт бичгүүд (*ОТ-14-PRC-0003-М*) - ээс лавлана уу.

## **6. НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ**

Осол зөрчлийн удирдлагын журам: Сургалт, Нэр томъёо тодорхойлолт болон холбогдох баримт бичгүүд (*ОТ-14-PRC-0003-М*) - ээс лавлана уу.

## **7. ЛАВЛАХ БОЛОН ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ**

Осол зөрчлийн удирдлагын журам: Сургалт, Нэр томъёо, тодорхойлолт болон Холбогдох баримт бичгүүд (*ОТ-14-PRC-0003-М*) - ээс лавлана уу.

## Осол зөрчлийн удирдлагын журам

Хүчин төгөлдөр болох огноо: 2014.03.01	Баримт бичгийн дугаар: ОТ-14-PRC-0001-М	Хувилбар: 2.0
---	--	------------------

### 8. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Баримтын нэр	ОТ-14-PRC-0001-М-Осол зөрчлийн удирдлагын журам
Тодорхойлолт	Осол зөрчлийн удирдлагын журам
Эх зохиогч(ид)	Никки Роуз, Жакоб Икарет, Баасансүрэнгийн Долгор, Бямбаагийн Идэрсайхан
Боловсруулсан огноо	2011.09.19
Баталсан	Айвэн Велла
Баталсан огноо	2012.04.16
Бүртгэлийн дугаар өөрчлөлт	##

Эрсдлийн түвшин	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдлийг үнэлсэн	Хянан шалгах давтамж	Дараагийн хяналтын огноо
Их	2012.04.16	Марк Слэйтэр	Жил тутам	2014.03.20

Хувилбар	Хувилбарын огноо	Зохиогч(ид)	Баталсан	Засварын талаарх мэдээлэл
1	2012.04.16	Маони Д.Альтерио	Бизнесийн бэлэн байдал хариуцсан дэд ерөнхийлөгч Айвен Велла, 14-р хэсгийн манлайлагч	Баталсан журам
1.1	2012.09.01	Маони Д.Альтерио	Бизнесийн бэлэн байдал хариуцсан дэд ерөнхийлөгч Айвен Велла, 14-р хэсгийн манлайлагч	Бүх осол, зөрчлийн үед анхны мэдээллийг дамжуулах эхлэлийг тавихыг тулд эмнэлэг хяналтын өрөөтэй яаралтай холбогдох талаар нэмэлт өөрчлөлтөд тусгасан.
1.2	2012.10.03	Н. Тогтуур	Б. Долгор	Баримт бичиг бүртгэл хяналтын удирдамжид нийцүүлэн форматыг шинэчилсэн. Агуулгыг өөрчлөөгүй.
1.3	2012.11.20	Маони Д.Альтерио	Маони Д.Альтерио	Нутгийн иргэдэд нөлөөлөх зөрчлийн тодорхойлолттой холбоотой БОННБҮ-ий шаардлагуудыг багтаасан.
1.4	2013.03.20	Л.Мөнхцацрал	Б. Долгор	Баримт бичгийн хяналтын удирдамжид нийцүүлэн форматыг шинэчилж, монгол хэлний орчуулгыг хянан засварлав. Агуулгыг өөрчлөөгүй.
2.0	2014.03.01	Маонни Д.Алтерио	Марк Слэйтэр	Бичиг баримтын хяналт хийж, агуулгад өөрчлөлт оруулсан. 8 алхам болон Үндсэн хүчин зүйлийн шинжилгээг оруулсан.

Үр дүнтэй судлах 8 алхам, Гол хүчин зүйл болон ART-T хэрэглүүрүүдтэй холбоотой ишлэлийг Интерсейф (Intersafe)-ийн зөвшөөрөлтэйгээр оруулав.